



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 1/36

Шивээговь сум

Хяналт шалгалтын ажил зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагч, Эрүүл мэндийн яамны салбарын улсын ерөнхий байцаагч нарын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 08-00-02/07 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх зөвлөмжийн дагуу сумын хэмжээнд хяналт шалгалтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: (1 дүгээр багийн Засаг дарга)
(Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

(Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа)

(Цагдаагийн хэсгийн жолооч)

Нарийн бичгийн дарга: (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

3. Хяналт шалгалтын ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг дүгнэн зохих арга хэмжээг авч ажиллан тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (М.Гантуяа)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42125 1 6

Сумын Засаг даргын 2025 оны 02-р сарын 26-ны өдрийн 36 дугаар захирамжийн хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Сумын Архи согтууруулах ундаа, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, албан байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга сэрэмжлүүлэг зөвлөгөө өгч ажиллахад оршино.

Хоёр. Хугацаа

Хяналт шалгалтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэх.

Гурав. Илэрсэн зөрчлийг шийдвэрлэх

Хяналт шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийг таслан зогсоож, холбогдох байгууллагад шилжүүлэн хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Дөрөв. Зохион байгуулагдах ажил

- Архи согтууруулах ундаа, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, стандартын хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах
- Хүнсний аюулгүй байдлыг хангаагүй бүтээгдэхүүн үйлчилгээг хураах, устгах арга хэмжээ авч ажиллах
- Архи согтууруулах ундаа, хүнсний худалдаа эрхлэгчдийн худалдан борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг хянаж шалгах
- Бүтээгдэхүүний хадгалалт, агуулахын шаардлага хангасан байдалд хяналт шалгалт хийх
- Архи согтууруулах ундаа, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой баримт бичгийн бүрдлийг шалгах